



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН  
НАМД

2024.08.06 № ГААТ-2024/13-ИТАНННД

танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020602

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхан сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сайхан сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД САЙХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС  
ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024-06-21

43 Хөтөл хот  
МЮА0065 9055436

**САЙХАН НУТГАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ**

Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа-2050”-г үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Сайхан сумын хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан, нэгтгэн дүгнэж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан Сайхан сумын Монгол Ардын намаас 2024-2028 онд Сайхан нутгийнхаа хөгжил дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж хэрэгжүүлэх ажлаа тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1. Эрүүл мэнд**

- 1.1.1 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биенеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчинөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй бодлого хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Эмч, сувилагчдыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургах, ур чадварыг нь дээшлүүлэн, ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлнэ.
- 1.1.4 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 1.1.5 Сумын эрүүл мэндийн төвүүдэд холын болон ойрын дуудлага гүйцэтгэх түргэн тусlamжийн автомашины парк шинэчлэлтийг хийх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 1.1.6 Орон нутагт өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, урамшуулах бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.1.7 Овоот, Дөмбөн хороололд эмийн сан шинээр байгуулах, сумын төв дэх эмийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн, 24 цагаар үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**1.2. Боловсрол**

- 1.2.1 Хүүхэд харах үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг ясли, цэцэрлэгт хамруулах зорилгоор гэр цэцэрлэг, өдөр

өнжүүлэх бүлгийг бий болгох иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж ажиллана.

- 1.2.2 Хүн амын өсөлт, хүртээмжид үндэслэн Овоот, Дөмбөн хороололд хүүхдийн цэцэрлэг, бага сургуулийн цогцолборыг шинээр барих ажлыг холбогдох төсөвт тусгуулах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.2.3 Боловсролын тухай хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсны дагуу бүх шатны сургалтын байгууллагад англи хэлийг <sup>4317143998</sup> эзэмших <sup>MCA00039053436</sup> нөхцөл, орчныг бүрдүүлж, англи хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулна.
- 1.2.4 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.2.5 Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд шаардагдах төсвийг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлэнэ.
- 1.2.6 Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй “Хүүхэд хөгжлийн төв”-ийг ашиглалтад оруулж, тоног төхөөрөмж, тохижилт үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэн үйл ажиллагааг тогтмолжуулна.

### **1.3. Соёл урлаг**

- 1.3.1 Соёлын төв, номын сан, орон нутаг судлах танхимын үзмэр, сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээ, сурталчилгааны чанарыг дээшлүүлнэ.
- 1.3.2 Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өв тээгчдийг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 1.3.3 Соёл урлагийн байгууллагуудын барилгын засвар, тохижилт, хөгжим, аппаратур, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

### **1.4. Биеийн тамир**

- 1.4.1 Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх орчныг бүрдүүлж, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэх олон талт арга хэмжээнд татан оролцуулах ажилд биеийн тамир, спортын салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 1.4.2 Хөтөл хотод шинээр биеийн тамирын “Спорт цогцолбор” байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 1.4.3 Сумын хэмжээнд үндэсний сур, шагайн харвааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.4 Орон нутгийн тамирчид, хүүхэд багачуудыг улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцоход зохих дэмжлэг үзүүлдэг болгоно.

### **1.5. Хөдөлмөр эрхлэлт**

- 1.5.1 Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн гарааны бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ борлуулалтын сүлжээг өргөтгөн төрийн худалдан авалтаар дэмжиж, “Нэг баг-нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.5.2 Хүнс, хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.5.3 Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад иргэд, аж ахуйн нэгжүүдийг эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангасан үйлчилгээ эрхлэх боломжийг олгож, дэмжиж ажиллана.
- 1.5.4 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өрнүүлэх замаар 4317143998 замаар 903нийгийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

## 1.6. Нийгмийн хамгаалал

- 1.6.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэн, иргэдийн оролцоотойгоор хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.6.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.6.3 Бага өртөгтэй түрээсийн орон байрны хангамжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж, хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.6.4 Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогын хүрээнд “Аз жаргалтай гэр бүл” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

## 2.1. Хариуцлагатай уул уурхай

- 2.1.1 Сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн лиценз эзэмшилтийг иргэдэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулна.
- 2.1.2 “Цемент Шохой” ХХК-ийн охин компани болох “Хөтөл энержи” ХХК-ийг Хөтөл хотыг дулаанаар хангах бие даасан дулааны станц болгох ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.3 Уул уурхайн нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг чангатгана.

## 2.2. Аялал жуулчлал

- 2.2.1. Аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг нэмэгдүүлж, аялал жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэнэ.
- 2.2.2. Уламжлалт соёл, орон нутгийн онцлогт тохирсон бренд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтлан орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.2.3. Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж, түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

### **2.3. Газар тариалан**

- 2.3.1 Үржил шим бүхий хөрсөнд тариалсан монгол таримын өрсөлдөх чадвар, үнэ цэнийг өсгөж, экспортыг нэмэгдүүлсэн, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлнэ.
- 2.3.2 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах, стратегийн хүнсний зориулалт бүхий хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх иргэн, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.
- 2.3.3 Төмс, хүнсний ногоо, хадлангийн газрыг зохих журмын дагуу сумын иргэдэд давуу эрхээр эзэмшүүлнэ.
- 2.3.4 Газар тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.3.5 Тариалангийн хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордооны хангамжийг 70 хувьд хүргэж, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлнэ.

4317143998

### **2.4. Мал аж ахуй**

- 2.4.1 Сумын хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн, малчин иргэдэд түгээн дэлгэрүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- 2.4.2 Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, мал амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- 2.4.3 Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан тэжээл, усны хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зэргээр мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.
- 2.4.4 Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал ахуй, гахай, тахиа, шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлнэ.
- 2.4.5 Малчин өрхийн амьжиргааг дэмжин, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх Шинэ хоршоо аяны хүрээнд “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.4.6 Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг олгох орчныг бий болгоно.
- 2.4.7. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлдэх аяныг зохион байгуулна.
- 2.4.8. Сүү хүлээн авах цэг байгуулах, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэл эрхлэх иргэдийн санаачилгыг дэмжиж, цэцэрлэг сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.

### **2.5. Байгаль орчин**

- 2.5.1 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах бодлого баримтлана.

- 2.5.2 Уул уурхай, газар тариалан, дэд бүтэц болон хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгон, эргэлтэд оруулж ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.
- 2.5.3 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлнэ.
- 2.5.4 Гол, булгийн эх, ус, намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажих, эзэмших, бохирдуулахаас сэргийлэн шингээх чадварыг хэвээр хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна.

4317143998

MIAA0065-9055436

## 2.6 Үйлдвэржилтийн бодлого

- 2.6.1 Төрийн өмчит “Цемент шохой “ХХК-г түшиглэн, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 2.6.2 Номгон тосгонд малын түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх болон тэжээлийн үйлдвэр байгуулах саналыг тус тус холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ-ШУДАРГА ЗАСАГЛАЛ

- 3.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.2 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж, төрийн хүнд суртлыг арилгана.
- 3.3 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 3.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.
- 3.5 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг бий болгоно.
- 3.6 Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж буй ажил, арга хэмжээнд дотоод хяналтыг чанартай гүйцэтгэж, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 3.7 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.8 Төрийн албан хаагчийг тасралтгүй сурч, хөгжих тогтолцоог бүрдүүлэн, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 3.9 Шаардлагатай тохиолдолд хотын эдийн засаг, тохижилт, нийгмийн өмнө тулгарч буй бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан, ард иргэдээр эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ

- 4.1 Сумын хүн амын бодит тоог нэмэгдүүлэх зорилгоор “10000+1” аяныг үргэлжлүүлнэ.
- 4.2 Хөтөл хотын нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн засвар, гадна фасад дулаалгын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын санхүүжилтийг шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.
- 4.3 Сум болон Номгон тосгоны дулаан болон цэвэр, бохир усны шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.4 Овоот, Дөмбөн, Жимстэй хорооллын хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах, өргөжүүлэх, зам талбайн гэрэлтүүлгийг сайжруулна.
- 4.5 Сумын төвийг дайран өнгөрч буй олон улсын чанартай замд явган хүний гүүрэн гарц хийх саналыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.
- 4.6 “Дулаан орц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, орц бүрд паар суурилуулж, орцны хаалгыг коджуулах, камержуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.7 Сумын төв доторх авто замыг хүчинтгэн шинэчилж, Жимстэй хороолол сумын төв хооронд сайжруулсан зам тавих ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 4.8 Гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж талбайн нэр, байшин барилгын хаягийн стандартыг ханггуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ.
- 4.9 Худалдаа үйлчилгээ, аялалд жуулчлалд зориулсан гудамжийг байгуулна.
- 4.10 Сумын наадмын талбайг тохижуулж, сэргээн засварлана.
- 4.11 Хүүхдийн парк болон соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнг засварлаж, сайжруулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН

- 5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.
- 5.2. Эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээг хийж агаар, хөрс, усны бохирдлыг багасган, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 5.3. Сумын төв болон Жимстэй хорооллын гудамж, талбай дахь тохижилтын ажлыг хийж, үерийн ус зайлуулах суваг, хоолой шинээр бий болгох ажлыг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 5.4. Хотын соёлыг хэвшүүлэх зорилгоор “Эрүүл иргэн–Эко хот” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 5.5. Хотын төвийн автомашины зогсоолыг нэмэгдүүлэх ажлыг иргэд, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 5.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг эхлүүлнэ.

Иргэдийнхээ хөгжих тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн бүтээмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй амар тайван хот болно.

Сайхан сумын Монгол Ардын намын хорооноос 2024 оны ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг та бид хамtran хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Сайхан нутгаа хамтдаа хөгжүүлье.